

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС
2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2018 оны 11 дүгээр сарын 29

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:



Тайлангийн хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1888 ширхгийг шинээр хэвлэн, 1005 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 51 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Түүнчлэн үйлчилгээний зааланд нийт 2000 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд 36 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, 2 аж ахуйн нэгж, байгууллагын 3 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэлээ.

2018 оны 11 дүгээр сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 16.5 хувиар, виз олголт 20.8 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 14.3 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 18.3 хувиар өсөж, хувийн урилга олголт 33.3 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 35.1 хувиар тус тус буурсан байна.

1.2. Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 28 иргэн, харьяалалгүй 7 хүн болон Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан гадаадын 6 иргэний баримт бичиг хянагдаж байна.

Мөн Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний баримт бичгийг хянан, Харьяатын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасны дагуу санал авах ажиллагааг хийлээ.

Монгол Улсын харьяатаас гарч бусад 3 улсын харьяат болох хүсэлт гаргасан 7 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүлээ.

Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 7 иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 17 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 24 иргэний хүсэлтэд санал авч, дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний баримт бичгийг хянан холбогдох байгууллагын саналыг авснаар Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 147 дугаар зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 28 иргэний мэдээллийг бүртгэн, мэдээллийн санд оруулах, Гадаад харилцааны яамны Консулын газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 94 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан байна.

Тайлант хугацаанд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах 4 байгууллагын хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, шинээр нээн үйл ажиллагаа эрхлэх 1 хүсэлтийг хэлэлцэн татгалзсан. Зөвшөөрлийн хугацааг сунгуулах 4 хүсэлт, шинээр нээн үйл ажиллагаа эрхлэх 1 хүсэлтийг хүлээн авлаа.

Байгууллагын дарга, хүүхэд үрчлэлт хариуцсан мэргэжилтэн Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын урилгаар “Олон Улсын Төлөөлөгчдийн Манлайллын Хөтөлбөр”-ийн хүүхэд үрчлэлтийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах айлчлалд оролцсон. Тус айлчлалын үеэр Америкийн Нэгдсэн Улсын гэр бүлд үрчлүүлсэн Монгол Улсын харьяат 24 хүүхдийн нөхцөл байдалтай Америкийн Нэгдсэн Улсын Виржиниа, Вашингтон ДС, Миссүрри, Ориган мужуудын Канзас, Портланд, Юужин хотод биечлэн очиж танилцлаа.

Мөн гадаадын 3 улсын гэр бүлд үрчлүүлсэн 4 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

1.3. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.3, 37.1.7, 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 8 улсын 56 иргэнийг байгууллагын даргын 20 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргаж, 1 улсын 2 иргэний албадан гаргасан шийдвэрийг хугацаанаас өмнө цуцалж, 1 улсын 1 иргэний албадан гаргасан хугацааг сунгасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1 улсын 4 иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 3 улсын 3 иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл, Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэдийн мэдээллийг 2 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар, Өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа буруу, нэрийн үсэг дутуу, визийн зориулалт бичигдээгүй нийт 15 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын виз олгох журамд заасны дагуу шинээр виз олгон хил нэвтрүүлсэн болно.

Мөн Монгол Улсад орох визгүй болон ирсэн зорилгодоо нийцсэн зохих ангиллын визгүй нийт гадаадын 44 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу тус тус орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба гарах-орох визгүй, виз авах байгууллагын албан хүсэлтгүй, оршин суух зөвшөөрөлд хасалт хийлгэх албан бичиггүй зэрэг үндэслэлээр гадаадын 12 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Албадан гаргагдсан гадаадын иргэдийн мэдээлэл:

№	Улс	ГИЭЗБТХ-ийн зүйлчлэл					Нийт
		37.1.2	37.1.3	37.1.7	37.1.11	37.1.12	
1	АБНЕУ	-	-	-	1	-	1
2	БНХАУ	4	1	27	4	12	48
3	БНТуркмену	-	-	-	-	1	1
4	БНТУ	-	1	-	-	1	2
5	ОХУ	1	-	-	-	-	1
6	Румын	-	-	-	1	-	1
7	ХБННУ	-	-	-	-	1	1
8	Япон	-	-	-	-	1	1
Нийт		5	2	27	6	16	56

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 1 захирамжаар гадаадын 1 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан үндэслэлээр 1 улсын 4 иргэнд гарах сануулга өгсөн.

Тайлангийн хугацаанд 5 удаагийн төлөвлөгөөт, 8 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 55 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 252 иргэнийг хамруулсан бөгөөд гадаадын 182 иргэн, 125 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 370 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 193,010,000 /нэг зуун ерэн гурван сая арван мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

“Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний тус байгууллагад холбогдох хэсгийн хэрэгжилт болон 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах санал, байгууллагын 2018 оны 10 дугаар сарын байдлаарх үйл ажиллагааны тоон мэдээг инфографик

хэлбэрээр, Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 42 дугаар тэмдэглэлтэй холбогдуулан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 3 дугаар улирлын биелэлт, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2018 оны 02 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын тус байгууллагад холбогдох хэсгийн хэрэгжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид, байгууллагын 2018 оны 10 дугаар сарын үйл ажиллагааны тайланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт тус тус хүргүүлж ажиллалаа.

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажил улсын хэмжээнд зохион байгуулагдаж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг ханган, хууль эрх зүй, мэдээллийн технологийн тестийн шалгалтад төв болон Буянт-Ухаа дахь газрын төрийн захиргааны 84 албан хаагчийг зохион байгуулалттайгаар хамрууллаа. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэгт холбогдох материалыг тухай бүр гарган өгч, баримт бичиг, ярилцлагын шалгалтад хамрагдлаа.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 48 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 34 өргөдөл шийдвэрлэгдэж, 14 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна.

Тайлант хугацаанд олон нийттэй харилцах чиглэлээр Харьяатын газрын дарга Монголын Үндэсний олон нийтийн телевизийн “Иргэний эрх зүйн боловсролд” нэвтрүүлэгт оролцож, “Иргэний харьяалал болон гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх” асуудлаар мэдээлэл өгсөн бөгөөд нэвтрүүлэг 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгээр “Гадаад иргэдийн хяналт шалгалт” сэдвээр 20 минутын нэвтрүүлэг бэлтгэж 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр тус тус Монголын Үндэсний олон нийтийн телевизийн Нэгдүгээр сувгаар цацагдаж, нэвтрүүлгийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудсанд байршуулсан. 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нээлттэй хэлэлцүүлгийн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчилж ажилласан бөгөөд тус хэлэлцүүлгийн мэдээ мэдээллийн 8 цахим хуудас, 3 телевизээр тус тус цацагдсан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх шатны зорилтын хүрээнд 2015, 2017 оны түр хадгалах баримтаас нийт 98 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэн, 2009-2017 оны нийт 4931 хадгаламжийн нэгжид нэгдсэн данс бүртгэл үйлдэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хот болон Чезү аралд “Цагаачлал, шилжилт хөдөлгөөний салбарын ирээдүйн манлайлагчдын 11 дүгээр хурал”-д 2 албан хаагч, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод “Нэг бүс нэг зам сургалт”-д 3 албан хаагч, “Хилээр орох гарах болон шилжилт хөдөлгөөний албан хаагчдын сургалт”-д 4 албан хаагч тус тус хамрагдсан. Мөн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга бэлтгэх, түгээх нэгдсэн арга зүй”-г боловсруулах сургалтад 1 албан хаагч, “Төрийн албаны хүний нөөцийн бодлого, удирдлага” сэдэвт богино хугацааны сургалтад 1 албан хаагч, байгууллагын мэдээллийн цагийн 4 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 175 албан хаагч хамрагдлаа.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг”-ийг иргэн, хуулийн этгээдүүдийн дунд 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт гадаадын иргэн, харьяалалгүй хүн, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 113 иргэн хамрагдаж, хуулийн төсөлд тусгуулах санал хүсэлтээ илэрхийлэн, хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг хүндрэл бэрхшээл, хуулийн ойлгомжгүй зүйл заалтын талаар санал бодлоо илэрхийлэн, асуулт асууж, холбогдох албан хаагчаас тухай бүр тайлбар, хариултыг өглөө.

Төрийн албаны тухай хуулийг /шинэчилсэн найруулга/ дагаж батлагдах журмуудын төсөлд холбогдох саналыг боловсруулан албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид хүргүүлсэн.

Байгууллагын дарга “Бүс ба Зам санаачилга, эдийн засгийн коридорын дагуу хилийн цаасгүй худалдааг хөгжүүлэх” төслийн шинжээч хатагтай Селила Рейсийг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагадаа хүлээн авч уулзлаа.

2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдох ажлын хүрээнд сүлжээний холболтыг 11 дүгээр сарын 07, серверийн тохиргоог 08-ны өдөр тус тус хийж дуусгаснаар бусад төрийн байгууллагуудтай мэдээллийн сангийн түвшинд мэдээлэл харилцан солилцох боломжийг бүрдүүлсэн бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй өгөгдлийг авах туршилтыг хийж эхлээд байна.

2.4. Дүн шинжилгээ, дотоод аудит, зөвлөгөө мэдээллийн чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар төлөвлөгөөт нийцлийн аудитын шалгалтыг хийж гүйцэтгэсэн ба байгууллагын дэд даргын баталсан удирдамжийн дагуу Санхүүгийн хэлтсийн санхүү болон худалдан авах ажиллагаанд дотоод аудитын хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд нийт 2048 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар нийт 1381, биечлэн 667 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Үүнээс виз, визийн зөвшөөрлийн талаар утсаар 650, биечлэн 300, Монгол улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, хасах талаар утсаар 450, биечлэн 326, бусад асуудлаар утсаар 281, биечлэн 41 иргэнд тус тус зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн ажлын талаар:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2018 оны төсөв 6,4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 11 дүгээр сарын байдлаар нийт 6,1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 2,9 тэрбум төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 399 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 165 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Мөн Өмнөговь, Дорнод аймаг дахь албаны барилгыг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгүүлэх талаарх холбогдох материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлээ.

2.6. Боомт, орон нутгийн чиглэлээр:

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн хүрээнд хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах зорилгоор Алтанбулаг, Сүхбаатар боомтын авто зам, барилга байгууламжийг шинэчлэх зураг төслийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй хийсэн 2 удаагийн уулзалтад байгууллагын төлөөлөл оролцсон.

Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудалд Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем /APP/-ийг "ISM" системтэй холбох гэж байгаатай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын харьяа Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд "SITA" байгууллагатай байгуулах гэрээний төслийг бэлтгэн Монгол Улсад Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл болон Иргэний нисэхийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газарт тус тус хүргүүлсэн.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР